## Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл

## Харилцаа холбооны зохицуулах хороо

## /2024 оны жилийн эцэс/

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин, үр дүн | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх | | | | | | | | |
| 1 | | 1.1 . Хорооны ХАСХОМ гаргах албан тушаалтны 2023 оны мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулах, холбогдох мэдээ тайланг АТГ-т хүргүүлэх арга хэмжээ авах | 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн дотор | Хорооны нийтийн албан тушаалтнуудыг 2023 оны ХАСХОМ гаргах үйл ажиллагаанд 100% хамруулсан байна. 2024.02.29-ний өдрийн дотор ХАСХОМ-1, ХАСХОМ хураангуй, ХАС-ын хураангуй тайлан мэдээг АТГ-т хүргүүлсэн байна. | Хорооны нийтийн албан тушаалтны 2023 оны ХАСХОМ-ийг бүрэн шинэчлэн гаргуулж, мэдээ тайланг нэгтгэн хуулийн хугацаанд АТГ-т хүргүүлсэн байна. | - | ХХЗХ-ны нийт 84 албан тушаалтны 2023 оны ХАСХОМ-ийг албан хаагчдаар гаргуулан, ХАСХОМ-1, ХАСХОМ хураангуй, ХАС-ын хураангуй тайланг ХХЗХ-ны 2024.02.20-ны өдрийн 1/285 тоот албан бичгээр болон АТГ-ын хариуцсан ажилтны албан мэйлээр цахимаар илгээсэн. ХАСХОМ гаргахад анхаарах асуудал сэдвээр сургалтыг тус Хорооны ЭБАТ, Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Нямдулам 2024.01.05-ны өдөр нийтийн албан тушаалтнуудад танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулсан. Хавсралт : 3 файл<br><br>Хавсралт : 3 файл | 100% |
| 2 | | 1.2. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн | Тухай бүр | ХХЗХ-ны Нийтийн албан тушаалд томилогдохоо нэр | -Нийтийн албанд томилогдох иргэний ХАСУМ- | - | ХХЗХ-ны нийтийн албан тушаалд тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ- | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг АТГ-аар хянуулах, хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилох, дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох | | дэвшсэн иргэн бүрийн ХАСУМ-ийг АТГ-аар хуулийн дагуу хянуулж, албан тушаалд томилсон байх | ийг АТГ-аар хянуулсан байх -Дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилсон байх -Дүгнэлтүүд нээлттэй, ил тод болсон байх | | аар тухай бүр хянуулж, ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилж байна. 2024 онд Хорооны ажлын албанд мэргэжилтэн буюу түүнээс дээш ангиллын албан тушаалд шинээр томилогдох, шилжин томилогдох 9 албан хаагч, иргэний жагсаалт, мэдээллийг Хорооны CRC.GOV.MN цахим хуудас болон "Шудрага ёс-хөгжил дэвшилд" мэдээллийн самбарт байршуулсан. https://www.crc.gov.mn/pages/show/avligaas-urdchilan-sergijleh-soyon-gegeer-leh-azhillagaa<br><br>Хавсралт : 1 файл | |
| 3 | | 1.3. Албан тушаалд томилсон хүний нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох | тухай бүр | Цахим хуудаст мэдээлэгдсэн нийтийн албан тушаалд томилсон, шилжүүлэн ажиллуулсан тушаал шийдвэрийн мэдээлэл | Албан тушаалд томилсон хүний нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох | - | ХХЗХ-ны нийтийн албан тушаалд тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар тухай бүр хянуулж, ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилж байна. 2024 онд Хорооны ажлын албанд мэргэжилтэн буюу түүнээс дээш ангиллын албан тушаалд шинээр томилогдох, шилжин томилогдох 9 албан хаагч, иргэний жагсаалт, мэдээллийг Хорооны CRC.GOV.MN цахим хуудас болон "Шудрага ёс-хөгжил дэвшилд" мэдээллийн самбарт байршуулсан. https://www.crc.gov.mn/pages/show/avligaas-urdchilan-sergijleh-soyon-gegeer-leh-azhillagaa | 100% |
| 4 | | 1.4. Хууль, журамд заасан үндэслэлээр албан хаагчдаас ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх | Тухай бүр | Албан тушаалтнаас гаргасан ашиг сонирхлын зөрчил | Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх мэдэгдэл, тайлбарыг хуульд заасан | - | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үндэслэл буюу албан тушаалтан шийдвэр гаргах, сахилгын арга хэмжээ авах, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэдэгдэл, тайлбарыг гаргуулж ажиллах | | үүссэн эсэх мэдэгдэл, тайлбар | үндэслэлээр гаргуулж, мэдүүлэг бүрдүүлэлтийн системд бүртгэх, холбогдох арга хэмжээг авч ажилласан байх | | гэрээ байгуулах, худалдан авах ажиллагаанд оролцох зэрэгт "Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх нийт 85 мэдэгдэл, тайлбар гаргасныг meduuleg.iaac.mn програмд оруулж бүртгэсэн. | |
| 5 | | 2.1. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл теле зохиомж, зурагт хуудас, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээ /фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг/, лед дэлгэц, сурталчилгааны сам | Жилийн турш | АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл теле зохиомж, зурагт хуудас, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээ /фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг/, лед дэлгэц, сурталчилгааны самбараар сурталчилсан байдал, тоо хэмжээ | АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл теле зохиомж, зурагт хуудас, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээ /фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг/, лед дэлгэц, сурталчилгааны самбараар олон нийтэд түгээн сурталилж, мэргэд олон нийт, нийт албан хаагчид мэдээлэл, ойлголт авсан байна. | - | АТГ-аас бэлгэсэн авлигын эсрэг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх агуулга бүхий сурталчилгааны материалуудыг Хорооны цахим хуудас болон Шудрага ёс-хбгжил дэвшилд мэдээллийн самбараар байршуулж олон нийт болон албан хаагчдад сурталчилж байна. АТГ-аас 2023 онд зарласан "Авлигын эсрэг нэгдье" "Шүгэл-авлигын эсрэг нэгье" аянд нэгдэж АТГ-аас бэлтгэсэн бусад видео контентийг байршуулж мэдээллийг олон нийтэд түгээсэн. https://crc.gov.mn/articles/avligyn-esreg-ayand-negde/mn https: //www.facebook.com/crcmongol Авилгыг мэдээлэх утас -110 Авилга гэж юу вэ? Авлигын хэлбэрүүд Авлига - Шудрага ёс Албан тушаалтанд хориглох үйлдэл, авлигын хор уршиг зэрэг сурталчилгааны материалуудыг байршуулсан. | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | | 2.2.. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг байгууллагын онцлогт тохируулан зохион байгуулах | 2024.2-3-р улиралд | Авлигын эсрэг зохион байгуулсан арга хэмжээний тоо, үр дүн, албан хаагчдыг хамруулсан байдал | Авлигын эсрэг нөлөөллийн болон сочн гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | 9 сая төгрөг | Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг Хорооны хэмжээнд төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. | Үнэлэх боломжгүй |
| 7 | | 2.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шудрага ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах | тухай бүр | Мэдээллийн самбарын мэдээллийг шинэчлэн, тогтмол байршуулж, мэдээлэл түгээсэн байх | Мэдээллийг тогтмол шинэчлэх | - | Авлигын эсрэг үйл ажиллагаа, авлигын эсрэг хууль тогтоомжийг мэдээлэн сурталчлах Шудрага ёс-хөгжил дэвшилд" самбарыг ХХЗХ-ны ажлын байранд байршуулж мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Мэдээллийн самбарт 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, 2024 оны эхний хагас жилд ХАСУМ хянуулж, ажилд томилогдсон албан хаагчийн жагсаалт, АТГ-аас гаргасан сурталчилгааны материал, ХХЗХ-ноос гаргасан" Авлигад үгүй гэж хэлье" "Бид авлигаас ангид байгууллага", "Авлигын хор уршиг" , "Авлигатай тэмцэх 5 үйл ажиллагаа", "Авлигын эсрэг нэгдье" зэрэг постерыг тус тус байршуулж, мэдээллийг тогтмол шинэчилж байна.<br><br>Хавсралт : 7 зураг | 100% |
| 8 | | 2.4.. Хорооны үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байлгахад чиглэсэн ёс зүй, шудрага байдлыг уриалсан агуулга бүхий /шторк, зурагт | 2024 оны 1 дүгээр улирал | | - Авлигын эсрэг 2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх -Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, албан | - | ХХЗХ-ны үйл ажиллагааг авлигаас ангид байлгахад чиглэсэн ёс зүй, шудрага байдал, авлигыг мэдээлэх 110 утсыг сурталчлах хүрээнд постерууд хийлгэж, Хорооны цахим хуудас болон хорооны пэйж хуудас, мэдээллийн самбаруудад байршуулж сурталчилж байна. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур, арга хэмжээ зохион байгуулах зэргээр сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх | | | ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /фэйсбүүк, твиттер, инстаграм, yuotube суваг/, лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх -Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх | | Хавсралт : 5 файл | |
| 2. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | | | | | | |
| 9 | | 1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, | | - Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх; - Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх; - Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших; - Тайланд холбогдох | | - | АТГ-аас бэлгэсэн авлигын эсрэг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх агуулга бүхий сурталчилгааны материалуудыг Хорооны цахим хуудас болон Шудрага ёс-хбгжил дэвшилд мэдээллийн самбараар байршуулж олон нийт болон албан хаагчдад сурталчилж байна. АТГ-аас 2023 онд зарласан "Авлигын эсрэг нэгдье" "Шүгэл-авлигын эсрэг нэгье" аянд нэгдэж АТГ-аас бэлтгэсэн шторкийг байршуулж мэдээллийг олон нийтэд түгээсэн. https://crc.gov.mn/articles/avligyn-esreg-ayand-negde/mn https://customer.crc.gov.mn/login Авилгыг мэдээлэх утас -110 Авилга гэж юу вэ? Авлигын хэлбэрүүд Авлига - Шудрага ёс Албан | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх | | нотломжийг хавсаргаж хэвших. | | | тушаалтанд хориглох үйлдэл зэрэг сурталчилгааны материалуудыг байршуулсан. | |
| 10 | | 1.2. Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах | | - Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; - Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; - Үр дүнг тооцсон байх. | | - | Авлигын эсрэг үйл ажиллагаа, авлигын эсрэг хууль тогтоомжийг мэдээлэн сурталчлах "Шудрага ёс-хөгжил дэвшилд" самбарыг ХХЗХ-ны ажлын байранд байршуулж мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Мэдээллийн самбарт 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, 2024 онд ХАСУМ хянуулж, ажилд томилогдсон албан хаагчийн жагсаалт, АТГ-аас гаргасан сурталчилгааны материал, ХХЗХ-ноос гаргасан" Авлигад үгүй гэж хэлье" "Бид авлигаас ангид байгууллага" зэрэг постерыг тус тус байршуулж, олон нийтэд сурталчилж байна. ХХЗХ-нд өргөдөл, гомдол ирүүлэх талаарх мэдээллийг тогтмол байршуулж, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдлыг мэдээлж ажиллаж байна. | 70% |
| 11 | | 1.3. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт | | - Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх; - Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн | | Видео контентыг 2.0 сая төгрөгөөр гэрээний үндсэн дээр бусдаар | ХХЗХ-ны авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тус Хорооноос хийлгэж, олон нийтэд түгээсэн постерууд болон видео контентэд авлигыг мэдээлэх утас 110, АТГ-ээс гаргасан "авлигын эсрэг нэгдье" уриаг давхар сурталчилан ажилласан.<br><br>Хавсралт : 5 зураг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах | | хэвлэмэл материалд оруулсан байх; - Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх; - Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. | | гүйцэтгүүлсэн. | | |
| 12 | | 1.4. Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх | | - Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; - Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх; - Олон нийтэд түгээсэн байх. | | -2,0 сая төгрөг | ХХЗХ-ны үйл ажиллагааг авлигаас ангид байлгахад чиглэсэн ёс зүй, шудрага байдал, авлигыг мэдээлэх 110 утсыг сурталчлах хүрээнд постерууд хийлгэж, Хорооны цахим хуудас болон хорооны пэйж хуудас, мэдээллийн самбаруудад байршуулж сурталчилж байна. Мөн ХХЗХ-ны үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд ил тод хүргэх, ХХЗХ-ноос олгодог харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, хугацаа сунгуулах хүсэлтийг цахимаар хүлээн авч байгаа болон Хорооноос бусад мэдээллийг түгээхтэй холбоотой цахим хуудсуудыг сурталчлан үйлчилгээг олон нийтэд түргэн шуурхай хүргэж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах агуулгаар видео контент хийлгэж, олон нийтэд түгээсэн. | 100% |
| 3. Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | | 3.1. Нийт албан хаагчид болон шинээр томилогдсон албан хаагчдыг ХАСХОМ мэдүүлэхэд анхаарах асуудал, авлигаас урьдчилан сэргийлэх сургалтад тус тус хамруулсан байх | 2024.1-4-р улиралд | Сургалт болон сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | Нийт албан хаагчид болон шинээр томилогдсон албан хаагчдыг ХАСХОМ гаргахад анхаарах асуудал, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулсан байх | - | 2023 оны ХАСХОМ-ыг шинэчлэн гаргахтай холбогдуулан ХХЗХ-ны ЭБАТ, Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Нямдулам "ХАСХОМ гаргахад анхаарах асуудал" сэдэвт сургалтыг нийтийн албан тушаалтнуудад 2024.01.05-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад 65 албан хаагч оролцсон. 2024 оны эхний хагас жилд томилогдсон 9 нийтийн албан тушаалтанд томилогдмогц ХАСХОМ хэрхэн үнэн зөв мэдүүлэх талаар мэдээ мэдээллийг тогтмол өгч ажилласан. Мөн 2024.04.12-ны өдөр Монголын хуульчдын холбоо болон АТГ-ын албан хаагчидтай хамтран албан хаагчдын дунд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь сэдвээр сургалт хэлэлцүүлэг зохион байгуулсан. ЭБАТ Б.Нямдулам "Авлигаас ангид төрийн алба" цахим сургалтад 2024 оны 09 дүгээр сард хамрагдсан.<br><br>Хавсралт нийт : 7 Файл : 2 Зураг : 5 | 100% |
| 14 | | 3.2. Хорооны орон нутаг дахь төлөөлөгчид, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд | 2024.2-4-р улирал | Мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээний тоо | Дотоод нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх | -2 сая төгрөг | Хорооны орон нутаг дахь төлөөлөгчид, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах хүрээнд . ТЗ эзэмшигчдэд харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, өөрчлөлт оруулах, хугацааг сунгах зэрэг хүсэлтийг цахимаар хэрхэн гаргах | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах | | | | | талаар сургалт, сурталчилгааны ажлыг шат дараатай зохион байгуулж байна. https://customer.crc.gov.mn/login Контентын нэр: Харилцаа холбооны зохицуулах хороо авлигын эсрэг Хугацаа: 1 минут 19 секунд Төрөл: Видео контент: Агуулга Харилцаа холбооны зохицуулах хороо нь дэвшилтэт техник, технологийг салбар бүрт нэвтрүүлэх, иргэдэд мэдээлэл харилцаа холбооны бүх төрлийн үйлчилгээг чанартай хүргэх, тэдгээрийн хүртээмжийг сайжруулах нөхцлийг бүрдүүлэхээр ажилладаг. Хорооны үйл ажиллагаа, шийдвэр, зохицуулалт, бусад холбогдох мэдээллийг crc.gov.mn, Хүүхдийн эрүүл мэнд, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөөтэй цахим тоглоом, хортой агуулга, цахим сүлжээнээс хүүхдийг хэрхэн хамгаалах талаарх зөвлөмж, зааварчилгааг https://www.ekids.mn/, Бүсчлэлийн кодын мэдээллийг ухаалаг гар утасны програм хангамж болон https://www.zipcode.mn/ цахим хуудсанд нэвтэрч тус тус авах боломжтой. Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах хүсэлтийг https://customer.crc.gov.mn/ болон e-mongolia цахим системээр дамжуулан гаргаж, үнэт цагаа хэмнээрэй. Мэдээллийн хаалттай байдал, хүнд суртал, чирэгдэл нь аливаа байгууллагын үйл ажиллагаанд шударга бус байдлыг бий болгох, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдлийг бий болгодог. Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа нэгдье. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Харилцаа холбооны зохицуулах хороо Авлигатай тэмцэх газар гэсэн агуулгаар тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон олон нийтэд зориулсан контент хийлгэж олон нийтэд түгээж байна. | | |
| 4. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | | | | | | | | | |
| 15 | | 4.1. .Бусад иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах | 2024.1-4-р улиралд | | Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах | - | ХХЗХ-ноос иргэн, хуулийн этгээдтэй байгуулж байгаа гэрээ хэлэлцээрт авлига ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хүрээнд дараах агуулга бүхий заалтыг заавал тусган оруулж, гэрээг байгуулж байна. 1.Талуудын төлөөлөгчид энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан нь эрх бүхий байгууллагын шалгалт, дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд гэрээг цуцлах үндэслэл болно. 2.Авлига, ашиг сонирхлын зөрчлийн улмаас учирсан хохирлыг буруутай этгээд нь эрүүгийн, захиргааны, сахилгын хариуцлага хүлээснээс үл хамаарч бүрэн хариуцна. 3.Гэрээг хэрэгжүүлэх явцад авлига, ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй, үүссэн тохиолдолд түүнийг мэдсэн этгээд Авлигатай тэмцэх газарт бичгээр болон 110 дугаарт утасдаж мэдэгдэх үүргийг хүлээнэ.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | |
| 5. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | | | | | | | | | |
| 16 | | 5.1. Авлигын эрсдэл ба авлига гарах | | Харилцаа холбооны салбарт үйл | Үйл ажиллагаанд эрсдэлийг | - | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүрээнд харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгох, сунгах, өөрчлөлт оруулах, зэрэг үйл ажиллагааг цахимжуулах, шат дамжлагыг бууруууулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авах | 2024.1-4-р улиралд | ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгох, сунгах, өөрчлөлт оруулах хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэсэн байдал, тусгай зөвшөөрлийг цахим системийн талаар олон нийтийг мэдээллээр хангасан байдал | тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх | | авч хэрэгжүүлэх хүрээнд харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгох, сунгах, өөрчлөлт оруулах, зэрэг үйл ажиллагааг цахимжуулах, шат дамжлагыг бууруууулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авах хүрээнд харилцаа холбооны салбарт тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг сунгах, өөрчлөлт оруулах зэрэг ажиллагааг хялбаршуулах, түргэн шуурхай болгох хүрээнд CUSTOMER.CRC.GOV.MN програмыг нэвтрүүлж, ашиглаж байна. Мөн ТЗ олгох үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн Зөвшөөрөл олгох дотоод үйл ажиллагааны журмыг батлан, мөрдөж байна. 2024 онд шинээр тусгай зөвшөөрөл шинээр авах нийт 118 хүсэлт ирсэнээс цахимаар 31 хүсэлт, зөвшөөрлийн хугацаа сунгуулах нийт 106 хүсэлт ирсэнээс цахимаар 38 хүсэлтийг ирүүлж, шийдвэрлэгдсэн. https://customer.crc.gov.mn/login | |
| 17 | | 5.2. Авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох хүнд суртлыг бууруулах чиглэлээр сургалт, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, | 2024.1-4-р улиралд | | Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээг зохион байгуулсан байх | - | ХХЗХ-ны албан хаагчдад 2024.04.12-ны өдөр "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сургалтыг Монголын хуульчдын холбоо, АТГ-ын албан хаагчидтай хамтран зохион байгуулсан. Сургалт хэлэлцүүлгийн хүрээнд Монголын хуульчдын холбооны Судалгааны төвийн судлаач Г.Оюунболд МХХ-ноос хийсэн "ХХЗХ-ны хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны дүн"-г | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шалтгаан нөхцөлийг арилгах талаар арга хэмжээ авсан байх | | | | | танилцуулж, цаашид анхаарах асуудал, АТГ-ын СГУСХ-ийн ахлах комиссар Д.Цэнд-Аюуш хэрэглэгчийн судалгааны дүнд үндэслэн авилга ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх зөвлөмжийг албан хаагчдад өгч, сургалтын эцэст сургалтад оролцогчдын дунд хэлэлцүүлэг хийгдсэн. Сургалт, хэлэлцүүлэгт танхим болон цахим хэлбэрээр нийт 62 албан хаагч оролцсон. Мөн сургалт хэлэлцүүлэгт АТГ-ын СГУСХ-ийн ажилтан Бямбадорж оролцсон. Тус Хорооны ЭБАТ Б.Нямдулам Удирдлагын академийн төрийн албан хаагчдад зориулсан "Авлигаас ангид төрийн алба" 1-р түвшиний 12 цагийн цахим сургалтад хамрагдсан.<br><br>Хавсралт нийт : 7 Файл : 2 Зураг : 5 | |
| 18 | | 5.3. ХХЗХ-ны хэмжээнд авлигын эрсдлийн судалгааг үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх, судалгааны үнэлгээ, дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ .зохион байгуулах | 2024 оны 1 дүгээр улиралд | | Эрсдлийн судалгааг хийлгэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байна. | -7 сая төгрөг | Монголын хуульчдын холбоотой "Авлигын эрсдлийн үнэлгээ хийх гэрээ"-г байгуулж, уг ажлыг 2024.09.16-2024.11.19-ны хооронд гүйцэтгүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 6. Хорооны удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл санаачлага өрнүүлэх | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | | 6.1. 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 1 дүгээр сард, хэрэгжилтийн явцыг 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор, хэрэгжилт, хүрсэн үр дүнг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор тус тус нийт албан хаагчдад танилцуулах | 2024.1-4-р улиралд | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг албан хаагчдад мэдээлсэн байдал, удирдлагаас өгсөн үүрэг чиглэл | Танилцуулах арга хэмжээг зохион байгуулж, үүрэг чиглэл өгсөн байх -Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жил тутамд мэдээлж, тайлагнасан байх | - | ХХЗХ-ны Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг ХХЗХ-ны даргаар 2024.01.15-ны өдөр ХХЗХ-ны даргаар батлуулж, нийт албан хаагчдад төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах талаар мэдээллийг хүргүүлсэн. Төлөвлөгөөг Хорооны цахим хуудаст байршуулж олон нийтэд мэдээлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар гарган crc.gov.mn цахим хуудас болон нийт албан хаагчдад мэдээлсэн. Эхний хагас жилийн авлигын эсрэг үйл ажиллагааны гүйцэтгэлийг гарган, 2024 лны 06 дугаар сарын 25-ны дотор khutulbur.iaac.mn програмд оруулж, тайлагнасан. | 100% |
| 20 | | 6.2. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачлага уриа, аянд нэгдэх | 2024.1-4-р улиралд | | Авлигын эсрэг санал, санаачлага, аянд нэгдсэн байх | - | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлээс гаргасан аянд нэгдэх арга хэмжээг тухай бүр дэмжиж, нэгдэн ажиллаж байна. АТГ-ын авлигын эсрэг нэгдье аянд нэгдэн Хорооноос гаргаж байгаа сурталчилгааны постер, видео контент зэрэгт авлигын эсрэг нэгдье санал, санаачлагыг тусган, сурталчилж байна. Хавсралт : 2 зураг | 70% |
| 7. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах | | | | | | | | |
| 21 | | 7.1. Авлигын эсрэг хууль болон Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Нийтийн мэдээллийн ил тод | 2024.1-4-р улиралд | | Хуулийг хэрэгжүүлж, иргэд олон нийтийг мэдээллээр хангасан байх | - | Авлигын эсрэг хууль болон Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасаны дагуу холбогдох мэдээллүүдийг CRC.GOV.MN цахим хуудаст тогтмол байршуулж, мэдээллийг шинэчилж байна. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд цахим хуудаст байршуулж, иргэд, олон нийт танилцах боломжоор хангах | | | | | Холбогдох мэдээлүүдийг тус Хорооны ЗУХАГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга, нягтлан бодогч, Нийтийн мэдээллийн сан, нээлттэй өгөгдөл хариуцсан мэргэжилтэн, Олон нийттэй харилцах мэргэжилтэн, Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Хүний нөөцийн мэргэжилтэн зэрэг албан хаагчид ажлын чиг үүргийн дагуу хариуцан оруулж байна. | |
| 8. хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах | | | | | | | | |
| 22 | | 8.1. Хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалтын түвшинд стандарт тогтоох холбогдох зохицуулалтыг бий болгоход дэмжлэг үзүүлэх | 2024.1-4-р улиралд | | Хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалт бий болгоход дэмжлэг үзүүлж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байх | - | ХХЗХ-ноос хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалтын түвшинд стандарт тогтоох холбогдох зохицуулалтыг бий болгоход дэмжлэг үзүүлэх чиглэлээр хийсэн ажлын дэлгэрэнгүй мэдээг хавсралтаар оруулав<br><br>Хавсралт : 1 файл | 100% |